



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/75

Бүрэн сум

Орон тооны бус зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 71 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/77 дугаар тушаалаар баталсан “Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм”-ийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумын хэмжээнд 55 нас хүрсэн эрэгтэй малчин, 50 нас хүрсэн эмэгтэй малчин даатгуулагчийн малчнаар ажиллаж байсан хугацааг тодорхойлох орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Б.Отгоншигт

(Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд

Ц.Лхагва

(Төхөм 1-р багийн Засаг дарга)

З.Пүрэв-Очир

(Баянцогт 2-р багийн Засаг дарга)

Д.Батмөнх

(Монгол 3-р багийн Засаг дарга)

Д.Батмөнх

(Эрдэнэхангай 4-р багийн Засаг дарга)

Б.Оюун-Эрдэнэ

(Өнжүүл 5-р багийн Засаг дарга)

П.Анхцэцэг

(Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Н.Өсөхбаяр

(Улсын бүртгэгч)

Нарийн бичгийн дарга:

Б.Болорцэцэг

(Сумын нийгмийн даатгалын байцаагч)

2. Орон тооны бус зөвлөлд **ДААЛГАХ** нь:

2.1. Даатгуулагчийн 1995 оноос хойшхи хугацаанд малчнаар ажиллаж байсныг нотлох “А” дансны лавлагаа, эсхүл энэ журмын 3.1.4-г заасан

412305173

даатгуулагчийн ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн тухай тушаал, хөлсөөр ажиллах (ажил гүйцэтгэх гэрээ, тэдгээртэй адилтгах) гэрээ байхгүй тохиолдолд түүний малчнаар ажиллаж байсан хугацааг сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) тодорхойлно гэснийг баримтлан тодорхойлох ба бусад тохиолдолд тодорхойлохгүй байх

2.2.1991 оноос 2022 оны хооронд дахь "Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тухайн оны тооллого"-ын жил бүрийн бүртгэл "А" дансны судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэн хурлын үйл ажиллагаанд ашиглах

2.3."Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөлийн дүрэм"-ийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасан эрх, үүргийг чанд баримтлан хуулийн дагуу хянан хэлэлцэж, түргэн шуурхай шийдвэрлэх

2.4.Зөвлөлийн гишүүд нь өөрийн хамаарал бүхий иргэний асуудлыг хэлэлцэхэд холбогдох хуулийн дагуу мэдүүлэг гарган ажиллах

2.5.Дээрх журам, дүрмийг баримтлан хэлэлцээгүйгээгээс Нийгмийн даатгалын санд учирсан хохирлыг холбогдох албан тушаалтан (тогтоолоор тодорхойлсон зөвлөл)-аар барагдуулах

2.6. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн архив, албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу хөтлөн баталгаажуулж, тогтоолын хувийг даатгуулагчид эх хувиар өгч, жил бүр хадгаламжийн нэгж үүсгэн ажиллах

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/32 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т ТҮВШИНБАТ